



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 156

Улаанбаатар хот

“Эрчим хүчний хөгжлийн төв”
төрийн өмчит үйлдвэрийн газрын
2018 оны үйл ажиллагаа, эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний
биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэхь хэсэг, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1,3.1,3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг “Хангалттай” гэж үзсүгэй.

2. “Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал А.Бямбадоржтой 2019 онд 1 жилийн хугацаатай контракт байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Төрийн өмчит үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс /Ц.Баяр-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000327